



### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** СЭА-2022/18/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>  Сүхбаатар сум  2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
	Утас: 7036-3040      Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>
	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 7036-3036      Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор: Т.Болор
	Утас: 7036-2442      Цахим хаяг: <a href="mailto:bolort@audit.gov.com">bolort@audit.gov.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал, дүгнэлт	4-6
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	7-12
3. Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	21
3.7. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	25
3.8. Аудитын гол асуудал	26
3.9. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	26
3.10. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	27
3.11. Дараагийн аудитаар анхаарах асуудал	27
4. Аудитын илрүүлэлт	29
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	38

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УОК	Улсын онцгой комисс
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМДХ	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс
ЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
ЭЭС	Эргэлтийн эмийн сан



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

ШААМАР СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Ф.СЕРИКБОЛ ТАНАА

2022.03.25 № СЭА-2022/18-НА-СТА-ТТЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Тайлант онд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчдад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар бус сүүлийн сарын үндсэн цалингаар тооцож, нийт 4,511.9 мянган төгрөг илүү олгосон. Үүнд:
  - ✓ Сумын ЗДТГ-ын архив, бичиг хэргийн ажилтан Н.Дугармаад 1,008.2 мянган төгрөг, ХАА-н тасгийн мэргэжилтэн Ц.Ганзоригт 362.2 мянган төгрөг,
  - ✓ Сумын ИТХ-ын нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Д.Цогтбаатарт 2,656.1 мянган төгрөг,
  - ✓ Дулаанхаан тосгоны Захирагчийн албаны архив, бичиг хэргийн ажилтан П.Эрдэнэдуламд 485.4 мянган төгрөг тус тус илүү олгосон байна.

- **Сумын ИТХ:**
  - ✓ Нарийн бичгийн дарга Б.Дариймаад 200.0 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг давхардуулан олгосон,
  - ✓ Сумын ИТХ-ын даргаар ажиллаж байсан /хууль бусаар ажлаас халагдсан нь тогтоогдсон/ С.Мягмартогтохт ажилгүй байсан хугацааны цалин болох 6,743.4 мянган төгрөгийг тус байгууллагын төсвөөс барагдуулсан боловч буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй.
- **Сумын ЗДТГ:**
  - ✓ Бараа үйлчилгээний бусад зардлын батлагдсан төсвөөс сумын Онцгой комиссын дарга, нарийн бичгийн дарга нарт 517.0 мянган төгрөгийн үнэ бүхий цэргийн хээрийн хувцас худалдан авч, өгсөн,
  - ✓ Сумын Засаг даргын 2021 оны Б/39 дүгээр захирамжаар улс төрийн албан хаагч болох сумын Засаг даргын орлогч Э.Учралд 194.0 мянган төгрөг, багийн Засаг дарга Д.Оюунтуяад 219.0 мянган төгрөг, Г.Отгонпүрэвт 219.0 мянган төгрөг зэрэг нийт 632.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон,
  - ✓ Цалингийн тооцооллыг зөрүүтэй хийсний улмаас ажиллагсадтай холбогдсон 850.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн.
- **Сумын ЭМТ:**
  - ✓ Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын төлбөрийн тооцоог тухай бүр хийж баталгаажуулаагүйгээс 725.0 мянган төгрөгийг дутуу, 1,850.0 мянган төгрөгийн орлогыг төрийн сангийн харилцах дансанд 2022 онд төвлөрүүлсэн,
  - ✓ Жилийн эцэст эд хөрөнгийн тооллого хийсэн боловч эмийн сангийн эмийн үлдэгдлийг тоолж, баталгаажуулаагүй,
  - ✓ Бараа үйлчилгээний бусад зардлаас нийт 12,242.1 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй,
- **Дулаанхаан тосгоны ЭМТ:**
  - ✓ Түлш, халаалтын зардлын хэмнэлт 6,000.0 мянган төгрөгийг оны эцэст татан төвлөрүүлэлгүйгээр нүүрс нөөцөлсөн,
- **Сумын Соёлын төв:**
  - ✓ Сахилгын шийтгэлтэй албан хаагч Б.Золбоод сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 202.4 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон.
- **Сум хөгжүүлэх сан:**
  - ✓ ИТХ-ын тогтоол шийдвэр гараагүй байхад буюу зарцуулах эрх үүсээгүй байхад батлагдсан төсвийг 9,494.9 мянган төгрөгөөр хэтрүүлэн зээл олгосон.
- Замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн "Шаамар сумын 3 дугаар баг Дулаанхаан тосгоны төв замын 120 метр бетон хучилт, сайжруулсан замын тэгшилгээ, тэмдэг, тэмдэглэгээ сэргээх ажил"-ын 79 хувийн гүйцэтгэлд 24,524.3 мянган төгрөгийн төлбөрийг гүйцэтгэгч Нобле роуд ХХК-д шилжүүлсэн байна.

Эдгээр зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.7, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Хөдөлмөрийн тухай хуулийн 134 дүгээр зүйлийн 134.4, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3, 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам”-ын 3 дугаар хавсралтын 2.7, 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 2.1, 3.2, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.12, 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн СЭАОНӨГ/202112045 дугаартай гэрээний тусгай нөхцөлийн 48 дугаар заалтуудыг тус тус зөрчсөн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>800,361.80</b>	<b>1,161,712.60</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	54,335.20	289,017.80
33	АВЛАГА	238,190.20	359,713.40
35	БАРАА МАТЕРИАЛ	507,836.40	512,981.40
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>12,686,195.70</b>	<b>12,676,767.00</b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,686,195.70	12,676,767.00
39200	Биет хөрөнгө	12,443,301.60	12,434,363.40
39300	Биет бус хөрөнгө	242,894.10	242,403.60
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>13,486,557.50</b>	<b>13,838,479.50</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>15,802.50</b>	<b>151,432.90</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,802.50	151,432.90
41300	Өглөг	15,802.50	151,432.90
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>13,470,755.00</b>	<b>13,687,046.70</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	13,470,755.00	13,687,046.70
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,375,458.00	2,375,458.00
51200	Хуримтлагдсан үр дүн	5,722,553.60	5,935,333.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,372,743.40	5,376,254.80
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>13,486,557.50</b>	<b>13,838,479.50</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>9,184,797.70</b>	<b>5,840,747.90</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>52,313.40</b>	<b>242,615.60</b>
110	Орлогын албан татвар	43,234.40	45,414.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	43,234.40	45,414.50
113	Хөрөнгийн албан татвар	720	43,398.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	8,359.00	153,802.20
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,704,202.20</b>	<b>704,490.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	3,704,202.20	704,490.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,428,282.00</b>	<b>4,893,642.20</b>
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,996,707.20</b>	<b>5,543,609.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,996,707.20</b>	<b>5,543,609.70</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,572,536.60	5,258,200.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,666,285.90	2,906,899.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	340,756.80	361,864.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	422,359.90	395,767.70
2104	Хангамж, бараа материалын зардал	107,630.50	166,336.30
2105	Нормативт зардал	261,494.90	469,743.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	113,964.20	87,714.60
2107	Томилолт, зочны зардал	3,701.80	3,691.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	91,143.50	102,943.30
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	565,199.00	763,241.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,424,170.70</b>	<b>285,408.80</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>3,188,090.40</b>	<b>297,138.20</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>305,523.80</b>	<b>83,870.00</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>2,882,566.60</b>	<b>213,268.20</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>1</b>	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>10,588,188.30</b>	-	<b>10,588,188.30</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	75,320.90	-	75,320.90
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,663,509.20	-	10,663,509.20
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(75,320.90)	-	(75,320.90)
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	2,882,566.60	-	2,882,566.60
<b>10</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>13,470,755.00</b>	-	<b>13,470,755.00</b>
<b>11</b>	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>13,470,755.00</b>	-	<b>13,470,755.00</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(487.90)	-	(487.90)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,470,267.10	-	13,470,267.10
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	3,511.40	-	3,511.40
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	213,268.20	-	213,268.20
<b>20</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>13,687,046.70</b>	-	<b>13,687,046.70</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	5,542,033.30	5,300,531.00
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	52,313.40	242,615.60
110	Орлогын албан татвар	43,234.40	45,414.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	43,234.40	45,414.50
113	Хөрөнгийн албан татвар	720.00	43,398.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	8,359.00	153,802.20
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,003.40	21,962.90
1181	Газрын төлбөр	2,866.70	4,544.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	488.90	127,295.30
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	61,437.80	143,935.20
120	Нийтлэг татварын бус орлого	61,437.80	143,935.20
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	5,428,282.00	4,913,980.20
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	5,447,903.40	4,825,571.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	5,447,903.40	4,825,571.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,026,632.90	4,511,134.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,664,025.70	2,859,027.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	342,161.80	363,634.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	423,444.80	398,819.70
2104	Хангамж, бараа материалын зардал	85,596.80	94,319.30
2105	Нормативт зардал	251,513.70	461,065.70
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	106,700.80	90,795.20
2107	Томилолт, зочны зардал	3,668.90	3,691.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	94,126.70	92,251.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,393.60	147,530.50
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,421,270.50	314,436.40
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	94,129.80	474,960.00
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	218,128.70	156,277.40
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	218,128.70	156,277.40
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	218,128.70	156,277.40
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	(218,128.70)	(156,277.40)
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	-	(84,000.00)
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	-	84,000.00
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	(123,998.80)	234,682.60
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	178,334.00	54,335.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	54,335.20	289,017.80

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,255,201.70</b>	<b>4,079,397.27</b>	<b>175,804.43</b>	<b>95.87</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,116,323.80</b>	<b>3,933,937.27</b>	<b>182,386.53</b>	<b>95.57</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,995,239.10</b>	<b>3,816,416.33</b>	<b>178,822.77</b>	<b>95.52</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,779,428.80	2,699,857.58	79,571.22	97.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	374,566.80	353,577.69	20,989.11	94.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	408,136.10	390,175.48	17,960.62	95.60
2104	Хангамж, бараа материалын зардал	81,680.80	77,568.58	4,112.22	94.97
2105	Нормативт зардал	138,159.30	93,883.12	44,276.18	67.95
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	94,349.30	90,979.30	3,370.00	96.43
2107	Томилолт, зочны зардал	4,954.60	3,170.30	1,784.30	63.99
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,283.80	50,571.95	3,711.85	93.16
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	59,679.60	56,632.33	3,047.27	94.89
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>121,084.70</b>	<b>117,520.94</b>	<b>3,563.76</b>	<b>97.06</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>64,372.80</b>	<b>61,460.00</b>	<b>2,912.80</b>	<b>95.48</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>74,505.10</b>	<b>84,000.00</b>	<b>(9,494.90)</b>	<b>112.74</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,255,201.70</b>	<b>4,078,491.68</b>	<b>176,710.02</b>	<b>95.85</b>
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,762,827.40	2,660,671.06	102,156.34	96.30
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,366,796.90	1,308,937.40	57,859.50	95.77
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	39,172.90	18,734.85	20,438.05	47.83
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	86,404.50	90,148.37	(3,743.87)	104.33
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	19,144.44	(19,144.44)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	18,238.85	(18,238.85)	-
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>1,631.00</b>	<b>4,711.00</b>	<b>(3,080.00)</b>	<b>288.84</b>
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	14.00	14.00	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	251.00	248.00	3.00	98.80
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	1,115.00	1,098.00	17.00	98.48
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	760.00	777.00	(17.00)	102.24
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	355.00	321.00	34.00	90.42
64	ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	-	3,103.00	(3,103.00)	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	251.00	248.00	3.00	98.80

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Зарцуулах эрх	Гүйцэтгэл
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>883,332.70</b>	<b>883,332.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>878,132.70</b>	<b>878,132.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>784,335.75</b>	<b>784,335.75</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,170.26	159,170.26
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,056.50	10,056.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,644.20	8,644.20
2104	Хангамж, бараа материалын зардал	17,422.16	17,422.16
2105	Нормативт зардал	367,182.57	367,182.57
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	86,811.94	86,811.94
2107	Томилолт, зочны зардал	520.67	520.67
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	43,629.26	43,629.26
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,898.19	90,898.19
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>93,796.95</b>	<b>93,796.95</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	73,299.00	73,299.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,497.95	20,497.95
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>5,200.00</b>	<b>5,200.00</b>
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>883,332.70</b>	<b>883,332.70</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>883,332.70</b>	<b>883,332.70</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,400.00	7,400.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	29,765.17	29,765.17
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	112,350.90	112,350.90
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	328,044.76	328,044.76
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	405,771.87	405,771.87

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /Шаамар сумын ТТЗ гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шаамар сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/54 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шаамар сумын ТТЗ нь тайлант онд “Хамтарч шийдье, хөгжин дэвшье” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа хэрэгжүүлсэн бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,

- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинээр мөрдөгдөхөөр батлагдсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хуультай холбоотойгоор 2020 онд Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр 60 дугаар зүйлийн 60.2.8-д малын тоо толгойн албан татварын орлогыг зарцуулах заалт шинээр нэмэгдсэн,
- Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан,
- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баталсан,
- Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” шинэчлэгдэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэгдэн батлагдсан,

- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн,
- Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж дүгнэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Шаамар сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шаамар сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,749,725.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 47,497.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 буюу 35,622.9 мянган төгрөгөөр урьдчилан тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 54,335.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 289,017.8 мянган төгрөг болж, 234,682.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Банканд байгаа бэлэн мөнгө	54,335.20	289,017.80	234,682.60	81.2
<b>Дүн</b>	<b>54,335.20</b>	<b>289,017.80</b>	<b>234,682.60</b>	<b>81.2</b>

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд тайлагнагдсан 270,778.9 мянган төгрөг ОНЕО-ын дансанд, 2,912.8 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 12,595.2 мянган төгрөг СХС-ийн дансанд, 2,730.9 мянган төгрөг Шаамар сумын ЭМТ-ийн /Ковид-19 цар тахалтай холбогдолтойгоор үлдэгдлийг татан төвлөрүүлээгүйгээс/ дансанд тус тус байршиж байна.

#### 3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 238,190.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 359,713.4 мянган төгрөг болж, 121,523.2 мянган төгрөгөөр буюу 51.0 хувиар өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,646.80	2,004.40	357.60
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	130,438.10	130,438.10
Зээлийн хүүгийн авлага	9,756.60	12,367.80	2,611.20
Бусад авлага	15,793.60	-	(15,793.60)
Зээлийн авлага	210,993.20	214,903.10	3,909.90
<b>Дүн</b>	<b>238,190.20</b>	<b>359,713.40</b>	<b>121,523.20</b>

Авлага дансны эцсийн үлдэгдэлд дараах авлагууд тайлагнагдсан байна. Үүнд:

- Сумын 1 дүгээр цэцэрлэг нь 54.4 мянган төгрөг, сумын ЗДТГ 850.0 мянган төгрөг, Дулаанхан тосгоны цэцэрлэг нь 1,100.0 мянган төгрөг зэрэг нийт 2,004.4 мянган төгрөгийн ажиллагчидтай холбоотой авлага,
- Шаамар сумын ЭМТ нь 21,904.6 мянган төгрөг, Дулаанхаан тосгоны ЭМТ нь 108,533.5 мянган төгрөг зэрэг нийт 130,438.1 мянган төгрөгийн ЭМДС-аас авах төлбөртэй үйлчилгээний авлага,
- Зээлийн 214,903.1 мянган төгрөг, зээлийн хүүгийн 12,367.8 мянган төгрөг зэрэг нийт 227,270.9 мянган төгрөгийн СХС-тай холбоотой авлагууд тус тус тайлагнагдсан байна.

Авлагын дансны үлдэгдэлд хугацаа хэтэрсэн 128,503.1 мянган төгрөгийн дараах авлагууд байна. Үүнд:

- СХС-ийн зээлийн хүүгийн 6,500.0 мянган төгрөгийн авлага,
- СХС-ийн зээлийн 122,003.1 мянган төгрөгийн авлага байна.

Тайлант онд хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулахаар Сэлэнгэ аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 16 зээлдэгчийн материалыг хүргүүлж, гарсан шийдвэрийг үндэслэн 14 зээлдэгчтэй эвлэрлийн гэрээ байгуулан хамтран ажилласнаар 11 зээлдэгчийн хугацаа хэтэрсэн чанаргүй зээлийн үлдэгдэл 12,476.6 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 507,836.4 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 512,981.4 мянган төгрөг болж, 5,145.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	22,193.20	22,261.80	68.60
Эм боох материал	22,505.70	25,589.30	3,083.60
Бэлэн бүтээгдэхүүн	18,973.20	47,855.10	28,881.90
Бичиг хэргийн материал	15,687.20	14,503.70	(1,183.50)
Аж ахуйн материал	275,889.20	242,700.20	(33,189.00)
Сэлбэг хэрэгсэл	7,984.80	8,864.10	879.30
Түлш, шатах тослох материал	4,963.50	7,692.00	2,728.50
Барилгын засварын материал	11,069.30	17,251.90	6,182.60
Хүнсний материал	3,686.40	3,125.40	(561.00)
Бусад хангамжийн материал	122,241.60	120,495.60	(1,746.00)
Мал амьтад	2,642.30	2,642.30	-
<b>Дүн</b>	<b>507,836.40</b>	<b>512,981.40</b>	<b>5,145.00</b>


Дээрх өсөлт нь тайлант онд 765,276.1 мянган төгрөгийн материал худалдан авсан, 109,308.0 мянган төгрөгийн материалыг шилжүүлэн авсан, 802,980.2 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан, 27,253.3 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгө рүү шилжүүлсэн, 39,205.7 мянган төгрөгийн бараа материалыг байгууллагын өмч хамгаалах комиссын шийдвэрийг үндэслэн байгууллагын даргын тушаалаар акталж, данс бүртгэлээс хассанаас шалтгаалсан байна.

#### **Аудитын илрүүлэлт:**

Дараах байгууллагууд нь бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Үүнд:

Шаамар сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

- Дулаанхаан тосгоны ЕБС нь 3,680.4 мянган төгрөгийн,
- Дулаанхаан тосгоны 3 дугаар цэцэрлэг нь тайлант онд 5,743.3 мянган төгрөгийн,
- Шаамар сумын ЕБС нь тайлант онд 80,189.9 мянган төгрөгийн,
- Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг нь тайлант онд 3,160.2 мянган төгрөгийн,
- Шаамар сумын 2 дугаар цэцэрлэг нь тайлант онд 2,747.3 мянган төгрөгийн гэх мэт



### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 14,660,351.1 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 14,701,353.0 мянган төгрөг болж, 41,001.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	11,114,743.40	11,214,217.80	99,474.40
Авто-тээврийн хэрэгсэл	346,334.30	393,258.30	46,924.00
Машин тоног төхөөрөмж(компьютер)	873,392.60	818,864.80	(54,527.80)
Тавилга, аж ахуйн эд хогшил	355,904.80	304,854.40	(51,050.40)
Зам, гүүрийн байгууламж	268,501.00	268,501.00	-
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	-	6,035.00	6,035.00
Бусад үндсэн хөрөнгө	1,386,086.00	1,391,970.80	5,884.80
Ном	68,768.60	57,010.50	(11,758.10)
Программ хангамж	13,749.00	13,769.00	20.00
Бусад биет бус хөрөнгө	232,871.40	232,871.40	-
<b>Дүн</b>	<b>14,660,351.10</b>	<b>14,701,353.00</b>	<b>41,001.90</b>

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 41,001.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр **94,817.4** мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, Дулаанхаан тосгоны ЭМТ-ийн барилгын их засвар 76,474.3 мянган төгрөг, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 23,000.0 мянган төгрөгийн хүнсний ногооны павильон, 85,340.0 мянган төгрөгийн дугуйт ачигч ковш, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 57,460.0 мянган төгрөгийн бетон зуурмагийн машин зэрэг нийт **321,751.4** мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан байна.

Аймгийн ИТХ-ын 2019 оны 134, 2021 оны 43, 124 дүгээр тогтоолуудаар сумын ЗДТГ-ын 4,000.0 мянган төгрөгийн, Дулаанхаан тосгоны ЭМТ-ийн 41,306.9 мянган төгрөгийн, Дулаанхаан тосгоны Захирагчийн албаны 11,250.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор 260,661.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан, ашиглалтын хугацаа дууссан 275,921.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг аймгийн ОНӨГ-ын даргын 2021 оны 87, 614, 685 дугаар тушаалуудаар тус тус ашиглалтын хугацааг сунгаж, 213,572.8 мянган төгрөгөөр үнэлэн, данс бүртгэлд тусгасан зэргээс шалтгаалсан байна.

### 3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны үлдэгдэл 15,802.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 151,432.9 мянган төгрөг болж, 135,630.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №5 Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Ажилчидтай холбогдсон өглөг	240.00	-	(240.00)	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	400.00	400.00	100.00
Байгууллагад төлөх өглөг	256.80	151,032.90	150,776.10	99.83
Хувь хүмүүст төлөх өглөг	15,305.70	-	(15,305.70)	-
<b>Дүн</b>	<b>15,802.50</b>	<b>151,432.90</b>	<b>135,630.40</b>	<b>89.56</b>

Нийт өр төлбөрийн үлдэгдэлд ЭМДС-ийн санхүүжилтийн дутуугаас сум, тосгоны ЭМТ-ийн бусад байгууллагад төлөх 130,438.1 мянган төгрөгийн өглөг, Дулаанхаан тосгоны Соёлын төв, сумын ЗДТГ-ын 20,337.9 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнагдсан байна.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 13,470,755.0 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 13,687,046.7 мянган төгрөг болж, 216,291.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт № 6 Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,375,458.00	2,375,458.00	-	-
Хуримтлагдсан үр дүн	5,722,553.60	5,935,333.90	212,780.30	3.58
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,372,743.40	5,376,254.80	3,511.40	0.07
<b>Дүн</b>	<b>13,470,755.00</b>	<b>13,687,046.70</b>	<b>216,291.70</b>	<b>1.58</b>

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь хуримтлагдсан үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5.7 Орлогын данс

Сумын ЗДТГ 3,500.0 мянган төгрөг, Дулаанхаан тосгоны Захирагчийн алба 5,760.0 мянган төгрөг зэрэг нийт 9,260.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр сумын ЗДТГ 4,298.2 мянган төгрөг,

Дулаанхаан тосгоны Захирагчийн алба 5,760.0 мянган төгрөг, нийт 10,058.2 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

### 3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой **68,840.0** мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

#### Аудитын илрүүлэлт:

- Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Ц.Болормаад ур чадварын нэмэгдлийг тогтоосон хувь хэмжээнээс илүү тооцож, 192.9 мянган төгрөг, Шаамар сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч А.Анужинд 154.1 мянган төгрөг зэрэг нийт 347.0 мянган төгрөгийг илүү тооцож олгосон,
- Тайлант онд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчдад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар бус сүүлийн сарын үндсэн цалингаар тооцож, сумын ЗДТГ 1,370.4 мянган төгрөг, сумын ИТХ 2,656.1 мянган төгрөг, Дулаанхаан тосгоны захирагчийн алба 485.4 мянган төгрөг зэрэг нийт 4,511.9 мянган төгрөгийг илүү олгосон,
- Шаамар сумын ЭМТ нь Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын төлбөрийн тооцоог тухай бүр хийж баталгаажуулаагүйгээс 725.0 мянган төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн,
- Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Дариймаад 200.0 мянган төгрөгийн албан томилолтын зардлыг давхардуулан олгосон,
- Сумын Соёлын төвийн сахилгын шийтгэлтэй албан хаагч Б.Золбоод сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 202.4 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон,
- Бараа үйлчилгээний бусад зардлын батлагдсан төсвөөс сумын Онцгой комиссын дарга, нарийн бичгийн дарга нарт 517.0 мянган төгрөгийн үнэ бүхий цэргийн хээрийн хувцас худалдан авсан,
- Сумын Засаг даргын 2021 оны Б/39 дүгээр захирамжаар улс төрийн албан хаагч болох сумын Засаг даргын орлогч Э.Учралд 194.0 мянган төгрөг, багийн Засаг дарга Д.Оюунтуяад 219.0 мянган төгрөг, Г.Отгонпүрэвт 219.0 мянган төгрөг зэрэг нийт 632.0 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон,
- ИТХ-ын тогтоол шийдвэр гараагүй байхад буюу зарцуулах эрх үүсээгүй байхад Сум хөгжүүлэх сангаас олгох зээлийн батлагдсан төсвийг 9,494.9 мянган төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан,
- Сумын ИТХ нь Сэлэнгэ аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 632, 2021 оны 155 дугаар шийдвэрээр сумын ИТХ-ын даргаар ажиллаж байсан /хууль бусаар ажлаас халагдсан нь тогтоогдсон/ С.Мягмартогтохт ажилгүй байсан хугацааны цалин болох 6,743.4 мянган төгрөгийг тус байгууллагын төсвөөс барагдуулсан боловч буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй,
- Замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн "Шаамар сумын 3 дугаар баг Дулаанхаан тосгоны төв замын 120 метр бетон хучилт, сайжруулсан замын тэгшилгээ, тэмдэг, тэмдэглэгээ сэргээх ажил"-ын гэрээний заалтыг зөрчин 79 хувийн гүйцэтгэлд 24,524.3 мянган төгрөгийг гүйцэтгэгч Нобле роуд ХХК-д олгосон байна.

- Сумын ЗДТГ нь цалингийн тооцооллыг зөрүүтэй хийсний улмаас ажиллагсадтай холбогдсон 850.0 мянган төгрөгийн авлага үүсгэсэн,
- Сумын ЭМТ нь Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын 1,850.0 мянган төгрөгийн орлогыг төрийн сангийн харилцах дансанд 2021 онд бус 2022 онд төвлөрүүлсэн,
- Дулаанхаан тосгоны ЭМТ нь түлш, халаалтын зардлын хэмнэлт 6,000.0 мянган төгрөгийг оны эцэст татан төвлөрүүлэлгүйгээр нүүрс нөөцөлж авч үлдсэн,
- Шаамар сумын ЭМТ нь жилийн эцэст эд хөрөнгийн тооллого хийсэн боловч эмийн сангийн эмийн үлдэгдлийг тоолж, баталгаажуулаагүй,
- Төсөвт зохицуулалт хийлгэлгүйгээр буюу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр сумын ЭМТ, Дулаанхаан тосгоны ЭМТ нь нийт 12,242.1 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан боловч гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын “Шаамар сумын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай” 29 дүгээр тогтоолоор тайлант онд 54,821.0 мянган төгрөгийн татварын орлого, 58,260.0 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт **113,081.0** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр **306,460.7** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 2.7 дахин давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт № 7 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Татварын орлого</b>	<b>54,821.00</b>	<b>242,615.70</b>	<b>187,794.70</b>	<b>4.4 дахин</b>
Үйл ажиллагааны орлого	10,000.00	7,950.20	(2,049.80)	(20.50)
Хөрөнгийн орлого	5,500.00	20,237.10	14,737.10	3.7 дахин
Хөрөнгө борлуулсны орлого	400.00	17,227.30	16,827.30	43 дахин
Бууны албан татвар	900.00	613.90	(286.10)	(31.79)
Улсын тэмдэгтийн хураамж	3,000.00	3,349.80	349.80	11.66
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	7,000.00	9,024.10	2,024.10	28.92
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	8,000.00	9,589.00	1,589.00	19.86
Газрын төлбөр	15,381.00	4,544.00	(10,837.00)	(70.46)
Дуудлага худалдаа	4,000.00	-	(4,000.00)	-
Ойн нөөц ашигласны төлбөр	-	125,082.30	125,082.30	-
Малын тоо толгойн албан татвар	-	42,785.00	42,785.00	-
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-	11.70	11.70	-
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	640.00	2,201.30	1,561.30	3.4 дахин

**Шаамар сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>Татварын бус орлого</b>	<b>58,260.00</b>	<b>63,845.00</b>	<b>5,585.00</b>	<b>9.59</b>
Торгуулийн орлого	46,000.00	51,429.70	5,429.70	11.80
Төсөвт байгууллагын өөрийн орлого	9,260.00	10,058.20	798.20	8.62
Бусад орлого	3,000.00	2,357.10	(642.90)	(21.43)
<b>Нийт орлогын дүн</b>	<b>113,081.00</b>	<b>306,460.70</b>	<b>193,379.70</b>	<b>2.7 дахин</b>

МЮА0883 9051436

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд ойн нөөц ашигласны төлбөр, малын тоо толгойн албан татварыг төлөвлөөгүй боловч гүйцэтгэлээр ойн нөөц ашигласны төлбөр 125,082.3 мянган төгрөг, малын тоо толгойн албан татвар 42,785.0 мянган төгрөг, төвлөрч, хөрөнгө борлуулсны орлого 16,827.3 мянган төгрөг, хөрөнгийн орлого 14,737.1 мянган төгрөгөөр тус тус давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

**Давж биелсэн орлогууд:**

- **Ойн нөөц ашигласны төлбөр:** Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур сумдыг холбосон улсын чанартай авто зам тавих ажилтай холбоотойгоор замын хажуугаар ургасан мод цэвэрлэгээний төлбөрийн орлогыг төлөвлөгөөнд тусгаагүй боловч гүйцэтгэлээр 125,082.3 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.
- **Малын тоо толгойн албан татвар:** Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр батлагдаж, 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан уг татварыг төлөвлөгөөнд тусгаагүй, гүйцэтгэлээр 42,785.0 мянган төгрөгийн орлого төвлөрсөнтэй холбоотой байна.
- **Хөрөнгө борлуулсны орлого:** Тайлант онд сумын иргэдийн эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн борлуулалт төлөвлөсөн хэмжээнээс нэмэгдсэнээс шалтгаалж орлого давж биелсэн.
- **Хөрөнгийн орлого:** Тайлант онд хадгаламж эзэмшигч иргэдийн хадгаламжийн хүүгийн орлогод тооцсон татварыг аймгийн Татварын хэлтсээс тус дансанд төвлөрүүлсэнтэй холбоотойгоор орлого давж биелсэн.

**Тасарсан орлого:**

- **Газрын төлбөр:** Газар эзэмшигчдийн газрын төлбөр төлөлт хангалтгүй байсантай холбоотой.
- **Дуудлага худалдаа:** Ковид-19 цар тахалтай холбоотойгоор газрын дуудлага худалдаа огт зохион байгуулагдаагүй тул орлого тасарсан байна.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4,259,962.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 4,259,962.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 07 дугаар тогтоолоор аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 1,157,720.1 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 60,083.4 мянган төгрөг, ЭМДС-аас санхүүжих 39,172.9 мянган төгрөг, ТЗШ-ийн байгууллагын санхүүжилтийг 2,820,811.7 мянган төгрөгөөр тус тус баталсан бол дээрх тогтоолыг үндэслэн сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 88 дугаар тогтоолоор сумын төсвийн орлогыг 113,081.0 мянган төгрөг, ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 93.3 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 69,000.0 мянган төгрөг зэрэг нийт 4,259,962.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын "Аймгийн 2021 оны тодотгосон төсөв батлах тухай" 2021 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 16 дугаар тогтоолоор тус суманд аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 10,943.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, ТЗШ-ийн байгууллагын санхүүжилтийг 34,466.8 мянган төгрөгөөр бууруулж баталсан байна.

Дээрх тогтоолыг үндэслэн сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор урьд оны үлдэгдлээс санхүүжих дүнг 34,228.6 мянган төгрөгөөр нэмж тодотгон, орон нутгийн байгууллагын зардлын санхүүжилтийг 45,172.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 4,278,719.2 мянган төгрөг болгон өөрчилж баталсан байна. Үүнд:

- Сумын ИТХ-ын зардлыг 12,743.4 мянган төгрөгөөр /хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд сумын ИТХ-ын төлөөлөгчдийг чадавхжуулах сургалт 4,000.0 мянган төгрөг, сумын ИТХ-ын даргаар ажиллаж байгаад чөлөөлөгдсөн С.Мягмартогтохын шүүхээр шийдвэрлэгдсэн цалингийн төлбөрт 6,743.4 мянган төгрөг/
- Сумын ЗДТГ-ын зардлыг 38,263.3 мянган төгрөгөөр /иргэний танхимын тохижилтын ажил 11,700.0 мянган төгрөг, 3,000.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас 4,000.0 мянган төгрөгийн 1 цэцэрлэгт НХЗЭ худалдан авах, бохир соруулах зардалд 3,590.8 мянган төгрөг, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор ЗДНХ-ийн зардлыг 16,923.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн/
- Дулаанхаан тосгоны Захирагчийн албаны зардлыг 16,558.6 мянган төгрөгөөр /Өндөр насны тэтгэвэрт гарсан 1 албан хаагчийн тэтгэмжид 15,185.9 мянган төгрөг, бохир соруулах төлбөрт 1,000.0 мянган төгрөг/ гэх мэт.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 4,278,719.2 мянган төгрөг төсөв батлагдсанаас аймгийн Засаг даргын 2021 оны А/372 дугаар захирамжаар ТЗШ-ийн байгууллагуудын төсөвт зохицуулалт хийгдэж, тус сумын ТЗШ-ийн байгууллагуудаас нийт 23,517.5 мянган төгрөгийг хасаж 2,762,827.4 мянган төгрөг болгосноос шалтгаалж **4,255,201.7** мянган төгрөг болж өөрчлөгдсөн байна.

Тайлант оны нийт төсвөөс 4,116,323.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 64,372.8 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, СХС-ийн зээлд 74,505.1 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 1,168,663.9 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 113,081.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, ЭМДС-аас 39,172.9 мянган төгрөгийг, 60,083.4 мянган төгрөгийг ОНХС-аас, 2,762,827.4 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 76,855.1 мянган төгрөгийг СХС-ийн олгосон зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс, ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 289.4 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 34,228.6 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 1,168,663.9 мянган төгрөг, ОНХС-аас 60,083.4 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 2,660,671.1 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 18,734.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 93,483.4 мянган төгрөг, сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээс 76,855.1 мянган төгрөг, оны эхний үлдэгдлээс 905.6 мянган төгрөг, нийт **4,079,397.3** мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,079,397.3 мянган төгрөг буюу 95.9 хувьтай тайлагнагдсан нь ЭМД-ын сангийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгосон, ТЗШ болон орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийн хэмнэгдсэн зардлыг татан төвлөрүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 100,560.3 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 17,960.6 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 4,112.2 мянган төгрөгөөр, нормативт зардал 44,276.2 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 3,370.0 мянган төгрөгөөр, томилолтын зардал 1,784.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 3,711.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 3,047.3 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 3,563.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 2 төсөл, арга хэмжээнд 64,372.8 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 61,460.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 2,912.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 7,600.0 мянган төгрөг, аймгийн ЗДНХ-өөс 29,765.2 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 112,350.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 328,044.8 мянган төгрөг, ЭМДС-аас 405,771.9 мянган төгрөг зэрэг нийт 883,332.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 159,170.3 мянган төгрөг, НДШ-д 10,056.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 8,644.2 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 17,422.2 мянган төгрөг, нормативт зардалд 367,182.6 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 86,811.9 мянган төгрөг, томилолт, зочны зардалд 520.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 43,629.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 90,898.2 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 73,299.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд *аймгийн ЗДНХ-өөс Дулаанхаан тосгоны цэцэрлэгт хуваарилсан хөрөнгөөр камер худалдан авсан* /5,200.0 мянган төгрөг зэрэг нийт 862,834.7 мянган төгрөгийг зарцуулж, 20,338.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

1. Засгийн газраас иргэдийн ус, дулаан, цахилгааны төлбөрийг чөлөөлсөнтэй холбоотойгоор усны 38,409.0 мянган төгрөгийн орлого төвлөрч, худгийн насос худалдан авах, засвар үйлчилгээ, цэвэр, бохир усны төлбөр, худаг гэрээгээр ажиллуулсан хөлс зэрэгт зарцуулсан байна.
2. Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 1 дүгээр зөвлөмжийг үндэслэн төрийн албан албаны нөөцөд бүртгэлгүй, хууль, албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангаагүй сонгон шалгаруулалтгүйгээр 4 албан хаагчдыг томилж, мөн зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар “Албан тушаалын сул орон тоог нөхөх зарим арга хэмжээний тухай” 411 дүгээр тогтоолын дагуу чөлөөлсөн байна.
3. Засгийн газрын 2009 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Сумын ЗДТГ-ын орон тооны хязгаарыг тогтоох тухай”, аймгийн Засаг даргын 2015 оны “Сумын ЗДТГ-ын бүтэц батлах тухай” 475 дугаар захирамжаар батлагдаагүй биеийн тамирын арга зүйч орон тоонд Б.Сүржавхланг 2018 оноос томилж, цалинжуулсан.
4. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор сумын ЭМТ-д ковидын тасаг ажиллуулснаас шалтгаалан тогтмол зардал төсөвлөсөн хэмжээнээс нэмэгдсэн тул нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан 7,500.0 мянган төгрөгийн тогтмол зардлын төлбөрийг гүйцэтгэсэн байна.
5. Сумын ЭМТ 16,000.0 мянган төгрөг, Дулаанхаан тосгоны ЭМТ 26,000.0 мянган төгрөг зэрэг нийт 42,000.0 мянган төгрөгийн багаж, техник хэрэгсэл худалдан

авахдаа үнийн судалгаа хийсэн талаарх холбогдох баримтгүй, зах зээлийн үнээс өндөр үнээр бэлтгэсэн байна.

6. Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалтын дагуу Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэх, Ковид-19 өвчний үед иргэдэд тусламж, тэтгэмж болгохоор 3,000.0 мянган төгрөгийн нүүрс худалдан авсан боловч тараалгүйгээр, жилийн эцэст бараа материалын үлдэгдлээр тайлагнасан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

1. Ковид-19 цар тахалтай тэмцэхэд зориулж иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас хандивласан 1,918.3 мянган төгрөгийг сумын ЗДТГ-ын Төрийн банкин дахь жижиг мөнгөн сангийн дансанд төвлөрүүлж, зарцуулсан байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд сумын ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт № 8 ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалт

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон
1	Сумын Засаг дарга	153	65	88
2	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	149	115	34
3	Сумын Засаг даргын Тамгын газар	149	122	27
4	Дулаанхаан тосгоны Захирагчийн алба	149	149	-
5	Сумын Эрүүл мэндийн төв	149	130	19
6	Дулаанхаан тосгоны Эрүүл мэндийн төв	149	142	7
7	Сумын Соёлын төв	149	46	103
8	Дулаанхаан тосгоны Соёлын төв	149	149	-
	<b>Нийт дүн</b>	<b>1196</b>	<b>918</b>	<b>278</b>

ТТЗ-ийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 1,196 мэдээллээс 918 мэдээллийг хугацаанд нь 278 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тайлант хугацаанд сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэмнэлтийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт № 9 ТТЗ-ийн харьяа байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэмнэлт

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэсэн хувь
1	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	99,322.60	97,355.10	2.00
2	Сумын Засаг даргын Тамгын газар	493,218.10	477,685.40	3.20
3	Дулаанхаан тосгоны Захирагчийн алба	169,473.40	166,510.50	1.80
4	Сумын Соёлын төв	139,246.00	126,217.60	9.40
5	Дулаанхаан тосгоны Соёлын төв	112,368.20	105,172.80	6.40
	<b>Нийт дүн</b>	<b>1,013,628.30</b>	<b>972,941.40</b>	<b>4.00</b>

ТТЗ-ийн харьяа 5 байгууллагын тайлант оны үйл ажиллагаанд 1,013,628.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 972,941.4 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 4.0 хувиар хэмнэсэн нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: "... батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 14,224.5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 38,359.0 мянган төгрөгийн албан шаардлага, 50,680.0 мянган төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгөгдсөнийг биелүүлж ажилласан байна.

Хүснэгт № 10 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	2	14,224.5	2	14,224.5	100.0
Албан шаардлага	9	38,359.0	9	38,359.0	100.0
Зөвлөмж	5	50,680.0	5	50,680.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>16</b>	<b>103,263.5</b>	<b>16</b>	<b>103,263.5</b>	<b>100.0</b>

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, төсвийн хөрөнгөөр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын



#### 4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн шууд захирагчийн 13 төсвийн байгууллага, орон нутгийн төсөл, сангийн 2, нийт 15 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 10 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа 5 байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Шаамар сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 681,465.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 61,916.9 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 7,135.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 61,704.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 550,708.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

**ТТЗ-ийн түвшний аудитаар нийт 564,863.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 41,182.7 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 6,788.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 61,704.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 455,187.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.**

##### 4.1 Залруулга

ТТЗ-ийн тайланд 41,182.7 мянган төгрөгийн залруулгыг хийлгэлээ. Үүнд:

- Сумын Соёлын төв нь 2020 онд үндсэн хөрөнгийн 19,278.1 мянган төгрөгийн элэгдэл байгуулаагүй,
- Сумын ЭМТ нь 21,904.6 мянган төгрөгийн ЭМДС-аас авах авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй.

##### 4.2 Төлбөрийн акт

1. Тайлант онд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчдад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар бус сүүлийн сарын үндсэн цалингаар тооцож, нийт **4,511.9** мянган төгрөгийг илүү олгосон байна. Үүнд:

- Сумын ЗДТГ-ын архив, бичиг хэргийн ажилтан Н.Дугармаад 1,008.2 мянган төгрөг, ХАА-н тасгийн мэргэжилтэн Ц.Ганзоригт 362.2 мянган төгрөг,
- Сумын ИТХ-ын нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Д.Цогтбаатарт 2,656.1 мянган төгрөг,
- Дулаанхаан тосгоны Захирагчийн албаны архив, бичиг хэргийн ажилтан П.Эрдэнэдуламд 485.4 мянган төгрөг тус тус илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 2.1 дэх “Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар тооцно.”, 3.2 дахь “Төрийн албанд ажилласан хугацааг тухайн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж буюу албан тушаалтан тооцож тодорхойлно. Төрийн албанд ажилласан хугацааг хуанлийн бүтэн жилээр тооцно.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэг удаагийн буцалтгүй тусламжийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

**2. Шаамар сумын ЭМТ** нь Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын төлбөрийн тооцоог тухай бүр хийж баталгаажуулаагүйгээс 725.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу төвлөрүүлсэн Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын орлогыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

**3. Сумын ИТХ-ын** нарийн бичгийн дарга Б.Дариймаад **200.0** мянган төгрөгийн албан томилолтын зардлыг давхардуулан олгосон /ЗГХЭГ, Удирдлагын академи, БНСУ-ын Нутгийн удирдлагын хөгжлийн институтийн хамтарсан “Төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх” чиглэлийн хүрээнд 4 өдрийн сургалтыг зохион байгуулж, албан томилолтын зардлыг тооцож олгосон/ байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон албан томилолтын зардлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

**4. Сумын Соёлын төвийн** сахилгын шийтгэлтэй албан хаагч Б.Золбоод сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад **202.4** мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 134 дүгээр зүйлийн 134.4 дэх “Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно.”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нэмэгдэл олгох журам”-ын 3 дугаар хавсралтын 2.7 дахь “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээлгэсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн урамшуулал олгохгүй” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй албан хаагчид олгосон үр дүнгийн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

**5.** ЗДТГ-ын бараа үйлчилгээний бусад зардлын батлагдсан төсвөөс сумын Онцгой комиссын дарга, нарийн бичгийн дарга нарт **517.0** мянган төгрөгийн үнэ бүхий цэргийн хээрийн хувцас худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан хөрөнгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

**6.** Сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Б/39 дүгээр захирамжаар улс төрийн албан хаагч болох сумын Засаг даргын орлогч Э.Учралд 194.0 мянган төгрөг, багийн Засаг дарга Д.Оюунтуяад 219.0 мянган төгрөг, Г.Отгонпүрэвт 219.0 мянган төгрөг зэрэг нийт **632.0** мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-ын 3-т “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл ... албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндэслэлгүйгээр илүү олгосон ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

#### **4.3 Албан шаардлага**

**1.** ИТХ-ын тогтоол шийдвэр гараагүй байхад буюу зарцуулах эрх үүсээгүй байхад **Сум хөгжүүлэх сангаас** олгох зээлийн батлагдсан төсвийг **9,494.9** мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: ИТХ-ын тогтоолоор батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах, зайлшгүй тохиолдолд ИТХ-д өргөн мэдүүлж, шийдвэрлүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

**2. Сумын ИТХ** нь Сэлэнгэ аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 632, 2021 оны 155 дугаар шийдвэрээр сумын ИТХ-ын даргаар ажиллаж байсан /хууль бусаар ажлаас халагдсан нь тогтоогдсон/ С.Мягмартогтохт ажилгүй байсан хугацааны цалин болох **6,743.4** мянган төгрөгийг байгууллагын төсвөөс барагдуулсан боловч буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна.

Энэ нь Иргэний тухай хуулийн 498 дугаар зүйлийн 498.5 дахь “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй.” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид /дотоод аудитын нэгж-д / гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг нөхөн төлүүлж, төсвийг хохиролгүй болгох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

**3. Замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн "Шаамар сумын 3 дугаар баг Дулаанхаан тосгоны төв замын 120 метр бетон хучилт, сайжруулсан замын тэгшилгээ, тэмдэг, тэмдэглэгээ сэргээх ажил"-ын 79 хувийн гүйцэтгэлд санхүүжилт 24,524.3** мянган төгрөгийг гүйцэтгэгч Нобле роуд ХХК-д шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн СЭАОНӨГ/202112045 дугаартай гэрээний тусгай нөхцөлийн 48 дугаарт заасан “ажлын гүйцэтгэл 100 хувьд хүрэхэд санхүүжилтийг 100 хувь олгоно” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээг хууль журмын дагуу үндэслэлтэй боловсруулж, гэрээний заалтыг мөрдөж байх албан шаардлага хүргүүлэх.

**4. Сумын ЗДТГ** нь цалингийн тооцооллыг зөрүүтэй хийсний улмаас ажиллагсадтай холбогдсон **850.0** мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, **авлага ба төлбөрийн тооцоог хянах,**

ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

**5. Сумын ЭМТ** нь Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын **1,850.0** мянган төгрөгийн орлогыг төрийн сангийн харилцах дансанд 2022 онд төвлөрүүлсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 3.12 дахь “Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж ... ” гэсэн заалтыг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Кассын орлогыг тухай бүр төрийн сангийн харилцах дансанд төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

**6. Дулаанхаан тосгоны ЭМТ** нь түлш, халаалтын зардлын хэмнэлт **6,000.0** мянган төгрөгийг оны эцэст татан төвлөрүүлэлгүйгээр нүүрс нөөцөлж авч үлдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь “... Төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд ... төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нүүрсний үлдэгдлийг 2022 оны хэрэглээнд суутган тооцож, хэмнэлтийг 2022 оны төсвөөс тооцож татан төвлөрүүлэх албан шаардлага хүргүүлэх.

**7. Сумын ЭМТ** нь жилийн эцэст эд хөрөнгийн тооллого хийсэн боловч эмийн сангийн эмийн үлдэгдлийг тоолж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна”, 12.2 дахь “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1 “жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй ажиллах, тооллого тооцоог хуульд заасан хугацаанд хийж байх албан шаардлага хүргүүлэх.

8. Сумын ЭМТ нь бараа үйлчилгээний бусад зардлаас **12,242.1** мянган төгрөгийн урсгал засварын материал худалдан авч, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргах үндэслэл болно” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай тохиолдолд төсвийн зохицуулалт хийлгэх албан шаардлага хүргүүлэх.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Төсвийн тодотголттой холбоотой асуудал:**

1.1 Илрүүлэлт: Аймгийн төсөвт тодотгол хийгдсэн гэх үндэслэлээр зайлшгүй шаардлага үүсээгүй байхад буюу сумын ИТХ, ЗДТГ-ын урсгал зардлыг ИТХ-ын хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх 4,000.0 мянган төгрөг, ЗДТГ-ын иргэний танхим тохижуулах 11,700.0 мянган төгрөг, компьютер худалдан авахад 3,000.0 мянган төгрөг, бусад хөрөнгийн зардалд 4,000.0 мянган төгрөгөөр 1 дүгээр цэцэрлэгт зөөлөн эдлэл худалдан авах/ санхүүжүүлэхээр нийт 22,700.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн тодотгол хийж, зарцуулсан байна.

Уг зөрчил нь Төсвийн тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.2 дахь “Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ”, 34.2.2: “Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Зайлшгүй нөхцөл бий болоогүй байхад байгууллагуудын урсгал болон хөрөнгийн зардлыг санхүүжүүлэхээр төсөвт тодотгол хийхгүй байх.

##### **2. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс сумын ОНХС нь “Бетон зуурмагийн машин” худалдан авах ажлын 44,676.3 мянган төгрөгийг барилгын зардлын зүйл дээр баталсан байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх” гэсэн заалт болон санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

### 3. Анхан шатны баримттай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэлгүйгээр нийт **371,811.2** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Үүнд:

- **Сумын ИТХ** нь 3,704.8 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтыг бодитоор тайлагнаагүй, жолоочийн тооцооны хуудсыг аргачлалын дагуу хөтлөөгүй, шатахуун олгох маршрутад явах км болон 100 км-т зарцуулах жишиг нормыг зөрүүтэй тооцсон,
- **Дулаанхаан тосгоны ЭМТ** нь 19,617.8 мянган төгрөгийн нүүрс, мод худалдан авч зарцуулсан боловч халаалтын тайлан гаргаагүй,
- **Сумын ЭМТ** нь сургалт сурталчилгаанд зарцуулсан 1,312.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр гүйцэтгэж, тайлагнасан,
- **ЗДНХ-өөс төсвийн тооцоо судалгаа хийлгүйгээр** 3,321.0 мянган төгрөгийн зардал гаргасан,
- **Сумын ЗДТГ** нь 68,395.2 мянган төгрөг, сумын ЭМТ нь 143,049.3 мянган төгрөг, сумын ИТХ нь 8,535.0 мянган төгрөг, сумын Соёлын төв нь 4,909.3 мянган төгрөг, Дулаанхаан тосгоны ЭМТ нь 69,369.9 мянган төгрөг, Дулаанхаан тосгоны Захирагчийн алба нь 17,159.7 мянган төгрөг, Дулаанхаан тосгоны Соёлын төв нь 5,783.7 мянган төгрөг нийт **317,202.1** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй,
- **Сумын ЭМТ** нь 6,500.0 мянган төгрөг, Дулаанхаан тосгоны ЭМТ нь 6,443.0 мянган төгрөг, сумын ЗДТГ нь 3,900.0 мянган төгрөг зэрэг нийт **16,843.0** мянган төгрөгийг албан хэрэгцээнд ашиглаж буй тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлд зарцуулсан боловч байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-өөс эдэлгээний хугацаа, уг засвар үйлчилгээг зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаар хэлэлцэж шийдвэрлээгүй, техникийн комиссын дүгнэлтийг үндэслээгүй,
- **Сумын ЭМТ** нь 2,450.0 мянган төгрөгийн Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын, сумын ЗДТГ нь 2,490.0 мянган төгрөгийн цемент, 4,870.0 мянган төгрөгийн урсгал засварын материал зэрэг нийт **9,810.0** мянган төгрөгийн худалдан авалтыг хүнсний дэлгүүрүүдээс хийсэн байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь ... хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж

баталгаажуулна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар “Маягт заавар батлах тухай” тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан “Автомашин сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар норм”-ын холбогдох заалтуудтай нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримт /хүчин төгөлдөр болон төлбөрийн цахим баримт/-ыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

#### **4. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтэй холбоотой асуудал**

4.1.1 Илрүүлэлт: ЗДТГ-ын үндсэн хөрөнгийн дансанд бараа материал бүртгэсэн байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-д “Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм” гэж тодорхойлсон заалттай нийцээгүй бөгөөд “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.1.2 Зөвлөмж: Дээрх хөрөнгүүдийг 2022 оны эхний хагас жилд багтаан үндсэн хөрөнгийн данснаас бараа материалын дансанд шилжүүлэн бүртгэж, залруулах.

4.2.1 Илрүүлэлт: Сумын ЭМТ нь “Лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх” 2/Г148 дугаартай гэрээний дагуу Монбиофарм ХХК-д гематологийн аппаратын төлбөр 16,000.0 мянган төгрөгийн бүрэн шилжүүлсэн боловч Ковид-19 цар тахалтай холбоотойгоор эмнэлгийн ажилтныг сургалтад хамруулж чадаагүй гэдэг шалтгаанаар бэлтгэн нийлүүлэгчээс уг аппаратыг одоог хүртэл хүлээн аваагүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2.2 Зөвлөмж: Дээрх хөрөнгийг 2022 оны эхний хагас жилд багтаан хүлээн авч, ашиглалтад оруулах.

Шаамар сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн						Үүнээс						
		Тоо		Дүн		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал														
1	Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчдад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар тооцоолуугээс сумын ЗДТГ, ИТХ, Тосгоны Захирагчийн алба илүү олгосон.	1	4,511.90					1	4,511.90					
2	Сумын ЭМТ Ковид-19 өвчнийг илрүүлэх оношлуурын тооцоог тухай бүр хийж, төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй.	1	725.00					1	725.00					
3	Сумын ИТХ-ын нарийн бичгийн даргад албан томилолтын зардлыг давхардуулан олгосон.	1	200.00					1	200.00					
4	Сумын Соёлын төвийн албан хаагчид сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад үр дүнгийн урамшуулал олгосон.	1	202.40					1	202.40					
5	Сумын Онцгой комиссын дарга, нарийн бичгийн дарга нарт цэргийн хээрийн хувцас худалдан авсан.	1	517.00					1	517.00					
6	Сумын Засаг даргын захирамжаар улс төрийн албан хаагч болох сумын Засаг даргын орлогч, багийн Засаг дарга нарт ур чадварын нэмэгдэл олгосон байна.	1	632.00					1	632.00					
7	Сумын ИТХ-ын тогтоол шийдвэргүйгээр Сум хөгжүүлэх сангийн батлагдсан төсвөөс хэтрүүлж зарцуулсан	1	9,494.90									1	9,494.90	
8	Сэлэнгэ аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 632, 2021 оны 155 дугаар шийдвэрээр сумын ИТХ-ын даргаар ажиллаж байсан /хууль бусаар ажлаас халагдсан нь тогтоогдсон/ С.Мягмартогтохт ажилгүй байсан хугацааны цалинг	1	6,743.40									1	6,743.40	



Шаамар сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

20	Сумын ЭМТ нь ЭМДС-аас авах авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй.	1	21,904.60	1	21,904.60						
21	Сумын Соёлын төв нь 2020 онд үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулаагүй.	1	19,278.10	1	19,278.10						
	<b>Дүн</b>	<b>21</b>	<b>564,863.20</b>	<b>2</b>	<b>41,182.70</b>	<b>6</b>	<b>6,788.30</b>	<b>8</b>	<b>61,704.70</b>	<b>5</b>	<b>455,187.50</b>
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчиж батлагдсан төсвийг 10-аас доош хувиар хэмнээгүй.	1						1			
2	Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	1						1			
	<b>Дүн</b>	<b>2</b>						<b>2</b>			
	<b>Нийт дүн</b>	<b>23</b>	<b>564,863.20</b>	<b>2</b>	<b>41,182.70</b>	<b>6</b>	<b>6,788.30</b>	<b>10</b>	<b>61,704.70</b>	<b>5</b>	<b>455,187.50</b>